



## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

1995 оны 12 дугаар  
сарын 15-ны өдөр

№.83

Улаанбаатар  
хот

### Улаанбаатарын "Дөрвөн уул" радио байгуулах тухай

Монгол улсын Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дүгээр заалтыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн төр, захиргаа, өөрөө удирдах байгууллагын бодлого шийдвэрийг олон түмэнд үнэн зөв, шуурхай түгээх, хотын олон талт амьдрал, иргэдийн санал бодлыг тусгах, төр, ард түмнийг холбож ажиллах үндсэн үүрэг бүхий Улаанбаатарын "Дөрвөн уул" радиог байгуулан ажиллуулсугай.

2. Улаанбаатарын "Дөрвөн уул" радиогийн бүтэц, орон тоо, шаардагдах төсөв хөрөнгө, ажлын байр, радиогийн суваг, студи, техникийн асуудлыг шийдэж, боловсон хүчнээр бэхжүүлэх арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг дарга /Ц.Баасанжав/-д даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-  
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮ-  
ЛЭГЧДИЙН ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-  
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-  
ДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.МАНАЛЖАВ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮН

П.ГАНБААТАР

Л.ГАРАМЖИЛ

П.ДАШНЯМ

Г.ЭЛЗИЙ

А.ЦАНЖИД

Б.ЦЭДЭВ

Ж.ЭРДЭНЭЧИМЭГ